

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ДЭГИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ  
АСУУДЛААР ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНООС  
ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2013 оны 12 дугаар  
сарын 18-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын  
гишүүн Ж.Батзандан**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн А.Бакей, Д.Эрдэнэбат, Н.Батцэрэг нар Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан боловсруулж, Улсын Их Хуралд 2013 оны 12 дугаар сарын 16-ны өдөр өргөн мэдүүлсэн байна.

Улсын Их Хурлын үйл ажиллагааг боловсронгуй болгож, гишүүний сонгогчийн өмнө хүлээсэн үүргээ шударгаар биелүүлэх нөхцөлийг бүрдүүлэх үүднээс хуралдаанд ирц бүрдүүлэхэд биеийн давхцахгүй өгөгдөл /гарын хурууны хээ/-ийн төхөөрөмж ашиглах эрх зүйн орчинг бүрдүүлэхээр уг хуулийн төслийг боловсруулжээ.

Төрийн байгуулалтын байнгын хороо хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг 2013 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцэж, Улсын Их Хурлын гишүүн Сү.Батболд, Л.Цог, М.Энхболд, Су.Батболд, Ж.Батзандан, Р.Гончигдорж нар үг хэлж, саналаа илэрхийлэв. Улсын Их Хурлын гишүүн Сү.Батболд Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслүүдийг нэгтгэн хэлэлцэх, ирц, санал хураалтыг нэг зарчмаар шийдвэрлэх; Улсын Их Хурлын гишүүн Су.Батболд энэхүү хуулийн төслийн дагуу гишүүний өглөөний ирцээр бүх асуудлыг шийдвэрлэх нь буруу; Улсын Их Хурлын гишүүн М.Энхболд биеийн давхцахгүй өгөгдлийн төхөөрөмжийг Улсын Их Хурлын даргын дэргэд байрлуулах нь зохимжтой биш болохыг анхаарах; Улсын Их Хурлын гишүүн Ж.Батзандан гишүүний хариуцлагын тогтолцоог сайжруулах шаардлагатай гэсэн саналыг тус тус гаргасан болно.


Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА**



**А.БАКЕЙ**